



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2018/01



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал




I.Нийгмийн байдал

I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 524, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 275 байгаагийн 154 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 42 буюу 18.0 хувиар, өссөн үзүүлэлттэй байна.

Нэгдүгээр сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 14 ажлын байрны захиалга иржээ. Тайлант сард ажилд зуучлагдсан иргэд байхгүй байна.

Зураг I.1.Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 59, 25-34 насны 101, 35-44 насны 59, 45-54 насны 46, 55 түүнээс дээш насны 10 иргэн байна.


I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 1 сарын байдлаар 37 эх амаржиж, 37 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 14 буюу 60.9 хувиар, төрсөн хүүхдийн тоо 13 буюу 54.2 хувиар тус тус өссөн байна.

Нас баралт 11, бүртгүүлсэн гэр бүл 4, цуцалсан гэр бүл 2 байгаа нь өмнөх оны мөн үеэс нас баралт 4 буюу 57.1 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 1 буюу 33.3 хувиар өсч, цуцалсан гэр бүл 2 буюу 50.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд үрчлэгдсэн хүүхэд байхгүй. Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 74 хүн шилжин ирж, 45 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 72.1 хувиар өсч, шилжин явалт 35.7 хувиар буурчээ.



Зураг I.2. Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 1 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2018 оны 1 сарын байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 345.6 сая төгрөг, зарлага 920.6 сая төгрөг болсон байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 67.3 хувьтай, зарлагын гүйцэтгэл 113.3 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны 1 сарын байдлаар 1553 хүнд 128.4 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 613 хүн буюу 65.2 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 53.6 сая төгрөг буюу 71.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2018 оны 1 сарын байдлаар 925 хүн хамруулж 67.7 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 243 хүн буюу 35.6 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 9.7 сая төгрөг буюу 16.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2018 оны 1 сарын байдлаар 628 хүн хамруулж 60.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 370 хүн буюу 2.4 дахин, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 44.0 сая төгрөг буюу 3.6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 1 дүгээр сарын мэдээгээр 170 байгууллагын 4105 даатгуулагч иргэн, үүнээс 231 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 321 даатгуулагчийн дундаж цалин 839.9 мянган төгрөг, төсөвт 52 байгууллагын 1459 даатгуулагчийн дундаж цалин 730.9 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 601 даатгуулагчийн дундаж цалин



1159.4 мянган төгрөг, 95 ХХКомпаний 1412 даатгуулагчийн дундаж цалин 1449.4 мянган төгрөг, бусад 10 аж ахуйн нэгж байгууллагын 81 даатгуулагчийн дундаж цалин 661.4 мянган төгрөг боллоо. Томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын 13 дах сарын цалин бодогдсонтой холбогдуулан сарын дундаж цалин өндөр гарсан болно.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2018 оны 1 сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2018 оны 1 сарын байдлаар 44 эх амаржиж, 2017 оны мөн үетэй харьцуулахад 11 буюу 33.3 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 44 үүнээс 12 нь хүү, 32 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 11 буюу 33.3 хувиар нэмэгдсэн байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл гараагүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн 1 сарын байдлаар



Халдварт өвчин 1 сарын байдлаар 20 буюу 10000 хүн амд 12.0 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор буурчээ.



Зураг III.2.Нас баралт, жил бүрийн 1 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 10.4 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.5 мянган хүнээр буюу 5.1 хувиар нэмэгдэж, 0.5 мянган өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 69 хүнээр буюу 12.5 хувиар буурсан байна.

2018 оны 1 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 730, халдварт өвчин 20 бүртгэгдсэн байна.


Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн 1 сарын байдлаар



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 1 сарын байдлаар 17 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 буюу 22.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 1 сарын байдлаар





Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 9 байгаа нь өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 36.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 10 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 10 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар өссөн байна.

Зураг IV.2. Гэмт хэргийн ангилал, жил бүрийн 1 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны 1 сарын байдлаар 23.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 11.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 12.0 сая төгрөгөөр буюу 34.3 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.0 сая төгрөг буюу 37.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны 1 сарын байдлаар давхардсан тоогоор 39 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 хүнээр буюу 18.8 хувиар буурсан байна.

Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн 1 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар, 2017 оны жилийн эцсээс 0.3 хувиар өссөн байна.



Хүснэгт V.1.Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 1 дүгээр сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2018.I}{2017.I}$	$\frac{2018.I}{2017.XII}$
Ерөнхий индекс	105.1	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	105.1	101.0
Согтууруулах ундаа, тамхи	104.0	102.3
Хувцас, бөс бараа, гутал	101.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	118.7	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.7	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	101.3	100.0
Тээвэр	111.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.3	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	99.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.0	100.0

Эх үүсвэр:Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ

**VI. Төсөв санхүү, банк**

2018 оны 1 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1075.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 1075.3 сая төгрөг болж 100.0 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 1835.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 920.2 сая төгрөг болж 50.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны 1 сарын байдлаар авлагын үлдэгдэл 17.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 33.9 сая төгрөг байна.

Зураг VI.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр






VII. Мал аж ахуй




Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 201476 хээлтэгч малаас 1 сард төллөлт бүртгэгдээгүй байна. 2018 оны 1 сарын байдлаар 2307 толгой том мал зүй бусаар хорогдсон байна. Өмнөх оны мөн үед том малын хорогдол гараагүй болно. Том малын зүй бус хорогдлын 6.5 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн 1 сарын байдлаар, толгойгоор



Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн 1 сарын байдлаар, толгойгоор



VIII. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2018 оны 1 сарын байдлаар 5168.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 273.9 сая төгрөг буюу 5.6 хувиар, оны үнээр 5770.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 547.4 сая төгрөг буюу 10.5 хувиар өслөө.



Шивээ-Овоо ХК нь нийт бүтээгдэхүүний 93.6 хувь буюу 4.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.3 хувь буюу 5.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн 1 сарын байдлаар, сая төгрөгөөр



IX. Цаг агаарын мэдээ 1 дүгээр сард:

/Говьсүмбэр аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр/

Хур тунадас: Энэ сард 6, 7, 13, 14, 15, 20-ний өдрүүдэд цас орж, нийт 1,3 мм тунадас унасан. Ихэнх хугацаанд 1 см зузаан цасан бүрхүүлтэй.

Салхи: 8, 22, 23, 28, 29-ний өдрүүдэд салхи зарим газраар түр зуур 10-13 м/сек хүрч ширүүссэн. Бусад хугацаанд салхи секундэд 3-8 метр байсан.

Агаарын температур: Өнгөрсөн сарын агаарын температур шөнөдөө 21-27-ний өдрүүдэд 30-37 градус хүйтэн, өдөртөө 20-26 градус хүйтэн, бусад хугацаанд шөнөдөө 23-28 градус, өдөртөө 9-14 хүйтэн байсан байна. Өнгөрсөн сарын хамгийн дулаан нь 13-ны өдөр -9,1 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь 22-ны шөнө -36,9 градус хүйтэн байсан.

ХОЁРДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын дундаж температур нь 15-20 градус хүйтэн буюу Говьсүмбэрийн нутгаар уур амьсгалын дунджаас 1.0-1.5 градусаар дулаан байх төлөвтэй.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхний хагаст шөнөдөө 27-32 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна. Харин нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч суларна. Мөн гуравдугаар арав хоногийн дунд үеэс хүйтний эрч харьцангуй суларч




шөнөдөө 17-22 градус, өдөртөө 2-7 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 16-21 градус, өдөртөө 4-9 градус хүйтэн байна.

Энэ сард Говьсүмбэрийн нутгаар уур амьсгалын дунджаас бага хур тунадас орох төлөвтэй.

Хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим газраар бага зэргийн цас орж, зөөлөн цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёр болон гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.





ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	33	44	133.3
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	233	275	118.0
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	16	20	125.0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	22	17	77.3
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	1070.6	1075.3	100.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	915.6	920.2	100.5
Авлага	сая.төг	26.4	17.3	65.5
Өглөг	сая.төг	30.8	33.9	110.1
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	4895.0	5168.9	105.6
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	5222.6	5770.0	110.5
Төллөсөн хээлтэгч	толгой	92	0	*
Гарсан төл	толгой	92	0	*
Хорогдсон төл	толгой	0	0	*
Бойжсон төл	толгой	0	0	*
Том малын зүй бусын хорогдол	толгой	0	2307	*



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	327	524	160.2
Үүнээс: эмэгтэй	182	307	168.7
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	233	275	118.0
Үүнээс: эмэгтэй	122	154	126.2
Ажлын байрны захиалга	44	14	31.8
Ажилд зуучлагдсан иргэд	10	0	*
Үүнээс: эмэгтэй	0	0	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Амаржсан эх	23	37	160.9
Төрсөн хүүхэд	24	37	154.2
Үрчлэгдсэн хүүхэд	0	0	*
Бүртгүүлсэн гэр бүл	3	4	133.3
Цуцалсан гэр бүл	4	2	50.0
Нас баралт	7	11	157.1
Шилжин ирсэн	43	74	172.1
Шилжин явсан	70	45	64.3

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 1 сарын байдлаар

Сангийн төрөл	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
ЭМНД-ын сангийн орлого, сая.төг	674.3	345.6	51.3
ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг	618.5	920.6	148.8

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I		2018 I		$\frac{2018 I}{2017 I} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	940	74.7	1 553	128.4	165.2	171.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	682	58.0	925	67.7	135.6	116.7
Халамжийн тэтгэвэр	187	32.6	190	27.8	101.6	85.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	495	25.4	735	39.9	148.5	157.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	258	16.8	628	60.8	243.4	361.9
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	45	0.09	3	0.3	6.7	333.3
Насны хишиг	0	0	405	35.3	*	*
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	32	0.8	31	1.0	96.9	125.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ	0	0	0	0	*	*
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	179	15.5	184	14.1	102.8	91.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	2	0.4	5	10.0	250.0	2500.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	0	0	0	0	*	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Төрсөн эх	33	44	133.3
Амьд төрсөн хүүхэд	33	44	133.3
Эрэгтэй	18	12	66.7
Эмэгтэй	15	32	213.3
Амьгүй төрсөн хүүхэд	0	0	*
Нийт нас баралт	9	5	55.6
Эмнэлгийн нас баралт	1	1	100.0
Хоног болоогүй нас баралт	1	0	*
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0	*
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0	*
Эмчлэгдсэн өвчтөн	551	482	87.5
Амбулаторийн үзлэг	9914	10 410	105.0
Халдварт өвчин	16	20	125.0

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн 1 сарын байдлаар , төрлөөр

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	22	17	77.3
Хүний амьд явах эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	10	11	110.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	9	2	22.2
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	2	*
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	0	*
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0	0	*
Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2	2	100.0



Бусад гэмт хэрэг	0	0	*
Гэмт хэрэгт холбогдогсод	15	12	80.0
15 хүртэлх насны	0	0	*
16-34 насны	8	9	112.5
35 ба түүнээс дээш насны	7	3	42.9
Боловсрол – Дээд	2	0	*
Боловсрол - Тусгай дунд	1	1	100.0
Боловсрол – Бүрэн дунд	7	7	100.0
Боловсрол – Бүрэн бус дунд	3	2	66.7
Боловсрол – Бага	1	1	100.0
Боловсролгүй	1	1	100.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	2	2	100.0
Ажилгүй иргэд үйлдсэн	5	10	200.0
Эмэгтэй хүн оролцсон	1	2	200.0
Хүүхэд оролцсон	0	0	*
Бүлгээр үйлдсэн	2	1	50.0
Согтуугаар үйлдсэн	7	7	100.0
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	22	17	77.3
Гудамж талбай, олон нийтийн газар	4	4	100.0
<u>Гэмт хэргийн улмаас нас барсан</u>	0	1	*
<u>Гэмт хэргийн улмаас гэмтсэн</u>	9	10	111.1
Учирсан хохирол / сая.төг /	35.0	23.0	67.6
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	8.0	11.0	137.5

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 1 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Нийт орлого	1 070.6	1 075.3	100.4
Урсгал орлого	342.7	317.1	92.5
Татварын орлого	239.5	298.8	124.8
Татварын бус орлого	103.2	28.3	27.4
Тусламжийн орлого	729.9	748.2	102.5

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Нийт зарлага	915.6	920.2	100.5
Урсгал зардал	900.6	739.4	82.1
Хөрөнгийн зардал	15.0	180.8	1205.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Авлага	26.4	17.3	65.5
Өглөг	30.8	33.9	110.1
Төсөвт байгууллагын тоо	49	49	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн 1 сарын байдлаар

Төрөл	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Бүгд	92	0	*
Ингэ	0	0	*
Гүү	0	0	*
Үнээ	25	0	*
Эм хонь	67	0	*
Эм ямаа	0	0	*

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн 1 сарын байдлаар

Сумд	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Дүн	92	0	*
<u>Баянтал</u>	0	0	*
Сүмбэр	92	0	*
<u>Шивээговь</u>	0	0	*



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн 1 сарын байдлаар

Төрөл	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Бүгд	92	0	*
Ботго	0	0	*
Унага	0	0	*
Тугал	25	0	*
Хурга	67	0	*
Ишиг	0	0	*

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн 1 сарын байдлаар

Сумд	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Дүн	92	0	*
<u>Баянтал</u>	0	0	*
Сүмбэр	92	0	*
<u>Шивээговь</u>	0	0	*

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 1 сарын байдлаар

Төрөл	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Бүгд	0	2 307	*
Тэмээ	0	0	*
Адуу	0	22	*
Үхэр	0	167	*
Хонь	0	411	*
Ямаа	0	1 707	*

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн 1 сарын байдлаар

Сумд	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Дүн	0	2 307	*
<u>Баянтал</u>	0	172	*
Сүмбэр	0	2 102	*
<u>Шивээговь</u>	0	33	*



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 1 сарын байдлаар

Төрөл	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Бүгд	0	149	*
Тэмээ	0	0	*
Адуу	0	4	*
Үхэр	0	25	*
Хонь	0	29	*
Ямаа	0	91	*

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн 1 сарын байдлаар

Сумд	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Дүн	0	149	*
<u>Баянтал</u>	0	42	*
Сүмбэр	0	99	*
<u>Шивээговь</u>	0	8	*

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Нийт	4 895.0	5 168.9	105.6
Нүүрс олборлолт	4 510.6	4 837.7	107.3
Боловсруулах үйлдвэр	103.2	15.8	15.3
Цахилгаан,дулааны эрчим хүч	281.2	315.4	117.6

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн 1 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Нийт	5 222.6	5 770.0	110.5
Нүүрс борлуулалт	4 943.0	5 443.6	110.1
Боловсруулах үйлдвэр	10.3	8.4	81.6
Цахилгаан, дулаан эрчим хүч	269.3	318.0	118.1



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн 1 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I	2018 I	$\frac{2018 I}{2017 I} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	4 943.0	5 443.6	110.1
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	4 510.6	4 837.7	107.3
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	199.6	214.1	107.3
Ажиллагсад	567	546	96.3

Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017